



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД Б.ЭНХБАЯР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД**

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170  
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,  
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2025.12.24 № 01/6666

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Үзэл баримтлалын төсөл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 87-д Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар тусгагдсан.

Монгол орны уур амьсгалын эрчимтэй өөрчлөлт болон хүний үйл ажиллагааны нөлөөгөөр хөрс, бэлчээр доройтох, цөлжилт идэвхжих, мөнх цас, мөсөн гол, цэвдэг хайлах, ган, зуд, хүчтэй салхи шуурга, аадар хур тунадас, үер зэрэг гамшигт үзэгдлийн давтагдал, учрах гарз хохирол ихээхэн нэмэгдэж, эдийн засгийн салбарт эрсдэл үүсэх, хүн амын амьдралын чанар доройтож, хот суурин газарт олноор шилжин суурьших болсноор агаар, хөрс, усны бохирдол нэмэгдэж, хүний эрүүл-аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөх хэмжээнд хүрээд байна.

Цаг уур, гадаргын ус, байгаль орчны хяналт шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлын хамрах хүрээ өргөжин тэлж, салбар дундын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, шинжлэх ухаан технологийн дэвшил, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх, цаг уурын мэдээг зах зээлийн харилцааны зарчим, шаардлагад нийцүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг шаардлага ч тулгарч байна.

Иймд 1997 онд батлагдсан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын Үзэл баримтлалын төслийг боловсруулан, хавсралтаар хүргүүлж байна. Үзэл баримтлалын төсөлтэй танилцаж, зохих хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгөхийг хүсье.

Хавсралт 6 хуудастай.

БАТЛАВ.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Б.БАТБААТАР

БАТЛАВ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙД

Б.ЭНХБАЯР

## **УС ЦАГ УУР, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах үндэслэл,  
шаардлага**

### **1.1. Хууль зүйн үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 87-д Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, “Нэгдсэн Үндэстний Байгууллагын гишүүн орны хувьд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын конвенц, Дэлхийн Цаг Уурын Байгууллага зэрэг олон улсын гэрээ, конвенцын өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай хэрэгжүүлэх, гадаргын ус, уур амьсгалын горимын хэмжилт, судалгааг олон улсын түвшинд хүргэх, хуулийн нэр томъёог шинээр тодорхойлох, ус цаг уур, орчны шинжилгээний улсын сүлжээний байршил, өртөө, харуулын шинжилгээний талбайн хэмжээнд өөрчлөлт оруулах, ус, цаг уур, орчны хяналт шинжилгээнд хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, архив, мэдээллийн сан эрхлэх, мэдээлэл үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, мэдээ, мэдээллээр хэрэглэгчдэд үйлчлэх, ус, цаг агаарын аюулт үзэгдлээс эрт сэрэмжлүүлэх тогтолцоог бэхжүүлэх болон салбарын албан хаагчдын нийгмийн баталгааны талаарх зохицуулалтыг тусгах”-аар заасан.

1997 онд батлагдсан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуульд 28 жилийн хугацаанд 2003, 2015, 2017, 2018, 2020, 2022 онуудад хийсэн 6 удаагийн өөрчлөлтөөр 1 бүлэг хүчингүй болж, нийт 21 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт хийгдсэн боловч бие даасан байдлаар ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д Монгол хүний эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, эрхийн баримт бичгийг хэрэгжүүлэх, экосистемийн тогтвортой байдлыг хангах, хүлэмжийн хийн ялгаралт багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон ногоон эдийн засгийг цогцлоон хөгжүүлэх чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлсэн.

Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, эрхийн баримт бичгүүд болох НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенц, Цөлжилттэй тэмцэх конвенц, Дэлхийн цаг уурын байгууллагын конвенц, Озоны үе давхаргыг хамгаалах тухай Вений конвенц, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн конвенц зэрэг олон улсын холбогдох гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

Манай улс сүүлийн 100 жилд ус цаг уур, орчны хяналт шинжилгээний

үндэсний сүлжээг ихэнх сум, суурин газарт байгуулан, цаг уур, гадаргын усны төлөв байдал, газар, бэлчээрийн доройтол, бэлчээрийн мэрэгч, хортон шавжийн тархалт, агаар, ус, хөрсний бохирдлын хяналт, шинжилгээ, судалгааг өргөн хүрээтэй хийж ирсэн. Үндэсний хэмжээнд хэрэгждэг энэхүү өргөн хүрээтэй үйл ажиллагааг орчин үеийн хөгжлийн чиг хандлага, техник технологийн хөгжил, нийгэм-эдийн засгийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхийн тулд 1997 онд батлагдсан Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгож, шинэчлэн найруулах зайлшгүй шаардлага үүсээд байна.

## **1.2. Практик шаардлага**

Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах практик шаардлага дараах байдлаар үүсэж байна. Үүнд:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль 1997 онд батлагдсан үеэс хойш цаг үеийн шаардлагаар уг хуульд 21 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч эдгээр нь зөвхөн бусад хуулийг дагаж орсон өөрчлөлт юм. Иймд байгаль орчин, нийгэм эдийн засгийн тодорхой салбаруудад зориулагдсан цаг уур, гадаргын усны тусгай хэрэгцээний мэдээлэл, үйлчилгээг өргөжүүлэх, зах зээлийн харилцааны зарчим, хэрэгцээ шаардлагад нийцүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.

2. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол орны уур амьсгал 1980-аад оны сүүл үеэс хойш эрчимтэй өөрчлөгдөж, энэхүү өөрчлөлт цаашид ч улам бүр эрчимжин үр дагавар нь нэмэгдэх хандлагатай байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, хүний үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нэмэгдсэнээр хөрс бэлчээр доройтох, цөлжилт идэвхжих, өндөр уулын хур цас, мөсөн гол, цэвдэг хайлах, ган, зуд, хүчтэй салхи шуурга, аадар хур тунадас, үер зэрэг гамшигт үзэгдлийн давтагдал ихсэж, учруулах гарз хохирол улам бүр нэмэгдэж байна. Иймд уур амьсгалын өөрчлөлтийн явц, түүний сөрөг үр дагавар, нөлөөллийг тасралтгүй ажиглаж хянах, болзошгүй аюул, эрсдэлийг судлан тогтоох, байгалийн аюул, гамшгаас урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж эрсдэлийг бууруулах, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт, дүгнэлт гаргах, холбогдох бодлого, хууль эрх зүйн орчныг оновчтой бүрдүүлэх шаардлага тулгарч байна.

3. Байгаль орчны доройтол, агаар-ус-хөрсний бохирдол зэрэг байгаль орчны төлөв байдлыг бодитой үнэлэх, ялангуяа хот суурин газрын агаар, орчны бохирдлын хяналт шинжилгээ, бодлого, арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй зөв төлөвлөх, хэрэгжүүлэх асуудал хурцаар тавигдаж байна. Гэтэл орчны бохирдлын асуудал Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, аймаг, нийслэлийн захиргааны байгууллагуудад, газар, бэлчээрийн асуудал Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд, байгалийн гамшгийн асуудал Шадар сайдын эрхлэх ажлын хүрээнд гэх зэргээр үндэсний ус цаг уурын байгууллагын гүйцэтгэдэг үйл ажиллагаа олон яам, агентлагт харьяалагдаж байгаагаас ажил давхардах, цалгардах, эзэнгүйдэх байдал гарч байна. Иймд эдгээр асуудлыг зохицуулах, тогтолцоог боловсронгуй болгох, салбар хоорондын ажлын уялдааг сайжруулах шаардлагатай байна.

4. Ус цаг уур, орчны эрдэм шинжилгээ, туршилт судалгааны хүрээлэн, төв нь нийгэм эдийн засгийн салбаруудад шаардлагатай уур амьсгалын судалгаа хийж, хот байгуулалт, барилга, эрчим хүч, дулаан хангамж, дэд бүтцийн шугам сүлжээ, нийгмийн эрүүл мэндийн салбарын уур амьсгалын норм, норматив боловсруулж, техникийн баримт бичгүүдэд тухай бүрд нь тусгаж, шинэчилж байх шаардлагатай

байдаг. Эдгээр баримт бичгийг тухай бүр өөрчлөхгүй байгаагаас холбогдох салбаруудад учирч болох эрсдэл нэмэгдэж, эдийн засгийн алдагдал хүлээсээр байгаа тул энэ асуудлыг уг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай байна.

5. Ус цаг уур, орчны шинжилгээний салбарт орчин үеийн техник, технологи нэвтэрч ус, цаг уур, орчны төлөв байдлын хяналт шинжилгээний ажлын цар хүрээ нь улам өргөжиж байна. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний хууль хэрэгжиж эхэлсэн үеэс хойш цөлжилт-бэлчээрийн төлөв байдал, бэлчээрийн даац, түүний хяналт шинжилгээний ажлыг Засгийн газрын 2000 оны 190, 2015 оны 286 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэж байна. 2015 оноос хойш багийн түвшинд, 1500 гаруй цэг дээр жил бүр бэлчээрийн төлөв байдал, бэлчээрийн даацын хяналт шинжилгээг хийж, Засгийн газар өвөлжилтийн төлөвлөлтөд үндсэн мэдээлэл болгон ажиглаж байна. Мөн өндөр уулын хур цас, мөстөл, цэвдэг, усны биологи, хөрсний усны түвшний өөрчлөлтийн хяналт шинжилгээг хийж байна. Эдгээр өргөн хүрээтэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх хууль эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох явдал чухлаар тавигдаж байна.

6. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний ажилд өндөр хүчин чадалтай супер компьютер, хиймэл дагуул, радарын техник, автомат багаж төхөөрөмж өргөнөөр ашиглах болсноор ус цаг уур, орчны анхдагч мэдээллийн хэмжээ эрс нэмэгдсэн. Цаг уурын ажиглалтын сүлжээнд дэлхийн олон орны өөр өөр үйлдвэрлэгчийн автомат төхөөрөмжийг нэвтрүүлэхэд Дэлхийн цаг уурын байгууллагын зөвлөмжийн дагуу багаж, тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, стандартын баталгаажуулалтын тогтолцоог сайжруулах, уур амьсгалын олон жилийн ажиглалтын цувааны нэг төрлийн байдлыг хангах зохицуулалтыг хуульчилж өгөх шаардлагатай байна. Энэ нь урьдчилсан мэдээний чанарыг сайжруулж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын ойрын хугацааны тэргүүлэх зорилт болох "Эрт сэрэмжлүүлгийг хүн бүрд" санаачилгыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь болно.

7. Агаар мандал, цаг агаарын төлөв байдал, үзэгдэлд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх, мөндөр задлах, манан сарниулах, хур борооны эрчмийг багасгах үйл ажиллагаа явуулах, цаг агаарт зориудаар нөлөөлөхөд ашиглагддаг химийн бодис, багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг дотоодод үйлдвэрлэх, угсрах, зохион бүтээх туршилтын үйл ажиллагааг өргөжүүлэх, техникийн аюулгүй байдлыг хангах, эдгээр үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог хангах, төр - хувийн хэвшил - шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжсэн хууль эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

8. Цаг уур, гадаргын ус, орчны бохирдлын талаар тусгай захиалгат болон төрөлжсөн мэдээллээр хэрэглэгчдийг хангах, хувийн салбарын оролцоог дэмжих зэрэг асуудлын зохицуулалт дутмаг байна.

9. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын хууль эрх зүйн зохицуулалт, бүтэц зохион байгуулалтыг өсөн нэмэгдэж байгаа ажлын цар хүрээ, хариуцлагатай уялдуулан боловсронгуй болгох, салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, тэдний цалин хөлс, нийгмийн хамгааллын асуудлыг салбарын онцлогийг тусгаж оновчтой шийдвэрлэх шаардлага нэмэгдэж байна.

### **Хоёр. Хуулийн шинэчилсэн найруулгын зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Тус хуулийн шинэчилсэн найруулгын зорилго нь үндэсний ус цаг уурын байгууллагын өсөн нэмэгдэж буй үйл ажиллагааны цар хүрээ, нийгэм, эдийн засгийн өсөлт, хэрэгцээнээс тавигдаж буй шаардлага, үйл ажиллагаатай уялдуулан

салбарын хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах юм.

Цаг уур, ус, орчны хэмжилт мониторингийн сүлжээг олон улсын шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх, орчин үеийн судалгааны арга технологи, тооцооллын загвар, хиймэл оюун ухаан, их өгөгдөл, үүлэн технологи, зайнаас тандан судлал, багаж, техник хэрэгслийг нэвтрүүлэх, салбарын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хоногийн 24 цагт, байгаль, цаг агаарын ямар ч нөхцөлд тасралтгүй үүргээ гүйцэтгэдэг ажлын онцлогийг харгалзан ажиллагсдын цалин, хангамж, нийгмийн хамгааллын асуудлыг бусад ижил төстэй байгууллага, салбартай ижил түвшинд тогтоох асуудлыг уг хуульд тусгах шаардлага тулгарч байна.

Шинэчлэн найруулсан хуулийн төслийг 10 бүлэгтэй байхаар боловсруулах бөгөөд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, шинэ болон шинэчилсэн нэр томъёоны (үндэсний хяналт шинжилгээний сүлжээ, ажиглалт шинжилгээний талбай, мэдээ, мэдээлэл, уур амьсгалын үйлчилгээ, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлууд, тусгай хэрэгцээний мэдээ, төрөлжсөн мэдээ, шинэ техник, технологи, тусгай зөвшөөрөл г.м) тодорхойлолтыг нэмж тусгана.

- Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт Ус цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээ, түүний удирдлага зохион байгуулалт, нэгж, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, ажиглалт, хэмжилтийн шаардлагын талаар тусгана. Мөн ус цаг уур, орчны хяналт-шинжилгээний улсын сүлжээг Дэлхийн цаг уурын байгууллагын шаардлага, стандартын дагуу өргөжүүлэн шинэчлэх, автомат станцаар тоноглох, цаг уурын радарын улсын нэгдсэн сүлжээ байгуулах, үндэсний өгөгдлийн нэгдсэн санд суурилсан систем хөгжүүлэх, шинэ арга технологи, аргачлал нэвтрүүлэх зохицуулалтын талаар тусгана. Түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх цаг уур, байгаль орчны төлөв байдлын ажиглалт, хэмжилтийн талбайн стандарт, хамгаалалтын бүсийг баталгаажуулах, тоног төхөөрөмжийн хэмжлийн нэгдмэл байдал, баталгаажуулалтын талаар тусгана.

- Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт ус цаг уур, орчны урьдчилсан мэдээ, нөлөөлөлд суурилсан урьдчилсан мэдээ, сэрэмжлүүлэг, ангилал, төрөл, хамрах хугацаа, мэдээллийг гаргах, дамжуулах, хэрэглэгчид хүргэх талаар нарийвчлан тусгана. Тусгай хэрэгцээний болон захиалгат судалгаа, үйлчилгээ явуулах, иргэний агаарын тээврийг ус цаг агаарын мэдээгээр хангадаг үндэсний бүрэн эрхт байгууллагын гүйцэтгэх үүрэг, хөдөө аж ахуйн цаг уур, био цаг уур, ойн цаг уур, техникийн уур амьсгалын мэдээллээр хэрэглэгчийг хангах, зах зээлийн харилцаанд нийцүүлэх талаарх зохицуулалтыг тусгана.

- Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт уур амьсгалын судалгаа шинжилгээ, үнэлгээ хийх, уур амьсгалын өөрчлөлтийн ирээдүйн хандлагыг тооцоолох, нөлөөлөл, эрсдэлийн үнэлгээ хийх, эх үүсвэрийн ялгарал, шингээлтийн тооллого хийх, мэдээллийн сан бүрдүүлэх талаар тусгана.

- Хуулийн төслийн тавдугаар бүлэгт ус цаг уур, орчны мэдээ, мэдээлэл, түүний архив, мэдээллийн сангийн талаар тусгана.

- Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт цаг агаарын төлөв байдал, үзэгдэлд зориуд нөлөөлөх үйл ажиллагааны зорилго, удирдлага зохион байгуулалт, аюулгүй байдлыг хангах талаар тусгана.

- Хуулийн төслийн долоодугаар бүлэгт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, үүргийн талаар тусгана.

- Хуулийн төслийн наймдугаар бүлэгт Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний албаны тогтолцоо, бүтцийг тодорхойлж, нэгдмэл байдал, төвлөрсөн удирдлагын талаарх зохицуулалтыг тусгана. Ус цаг уур, орчны шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үүрэг, статусыг өөрчлөн (ерөнхий газар болгох) ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, орчны бохирдол, байгалийн гамшигт үзэгдлээс эрт сэрэмжлүүлэхтэй холбоотой ажиглалт, хяналт шинжилгээ судалгаа, мэдээллийн үйлчилгээний ажлыг хариуцан гүйцэтгэх, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, салбар дундын зохицуулалтын талаар тусгана. Мөн салбарын эрдэм шинжилгээ судалгааны хүрээлэн, төв, лаборатори, экспедиц, орон нутгийн байгууллагуудын статус, үйл ажиллагааны талаар тусгана. Түүнчлэн ус цаг уур орчны хяналт шинжилгээний салбарын ажилтны эрх үүрэг, нийгмийн баталгаа, цалин, хангамж, хөнгөлөлт, урамшуулал, нийгмийн хамгаалал, ажлын онцлогийг тусгасан хөдөлмөрийн үнэлгээний талаар тусгана.

- Хуулийн төслийн есдүгээр бүлэгт ус цаг уур, орчны хяналт шинжилгээний мэдээллийн үйлчилгээний төрөл, ангиллын талаар тусгана. Төлбөргүй болон төлбөртэй үйлчлэх нөхцөл, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох журмын талаар тусгана. Түүнчлэн нисэхийн цаг уурын үйлчилгээг иргэний нисэхийн олон улсын гэрээ, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын дүрэм журамд нийцүүлэн үзүүлэх талаар тусгана. Энэхүү бүлэгт тусгай хэрэгцээний болон төрөлжсөн мэдээллээр үйлчлэхэд иргэн, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоо, тэдгээрт тусгай зөвшөөрөл олгох, тэдний гаргасан мэдээ, мэдээллийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталгаажуулах талаар тусгана.

- Хуулийн төслийн аравдугаар бүлэгт олон улсын хамтын ажиллагаа, ус цаг уур орчны шинжилгээний салбарын судалгаа шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, хуулийг зөрчсөн албан тушаалтан, хувь хүн, байгууллага, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай зэрэг холбогдох асуудлыг тусгана.

**Гурав. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

1. Хуулийн шинэчилсэн найруулга батлагдсанаар цаг уур, уур амьсгал, гадаргын ус, байгаль орчны төлөв байдлын тухай бүх төрлийн мэдээллийн чанар, хүртээмж сайжирч, байгалийн аюулт, гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх систем боловсронгуй болж, учирч болох гарз хохирлыг бууруулах бодит боломж бүрдэж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах баталгаа дээшилнэ.

2. Уур амьсгалын өөрчлөлтийн суурь судалгаа, эрсдэлийн үнэлгээг өргөжүүлснээр уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг даван туулах чадавхыг бэхжүүлэхэд шинжлэх ухааны чухал үндэслэл болно.

Монгол Улсад төрийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж байгаа ус цаг уур, байгаль орчны хэмжилт, судалгааны багаж төхөөрөмжийн харьцуулалт, баталгаажуулалт, гэрчилгээжүүлэлт, мэдээ, өгөгдлийг мэдээллийн нэгдсэн санд хадгалах, цахимжуулах зэрэг асуудлыг хуульчлан зохицуулах боломж бүрдэнэ.

3. Үндэсний ус цаг уурын байгууллага нь 1940 оноос эхлэн иргэний нисэхийг цаг агаар, уур амьсгалын мэдээгээр байнга хангаж ирсэн боловч 2000 оноос олон улсад мөрдөгдөж эхэлсэн иргэний нисэхийн дүрмийн дагуу Засгийн газар иргэний нисэхийн цаг уурын мэдээллийн үйлчилгээ эрхлэх бүрэн эрхт байгууллагыг өнөөдөр хүртэл албан ёсоор томилоогүй байгаа ба шинэчилсэн найруулга нь энэхүү хууль

эрхзүйн зөрчлийг арилгана.

**Дөрөв. Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төслийн хүрээнд Агаарын тухай, Газрын тухай, Зөвшөөрлийн тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Иргэний нисэхийн тухай, Харилцаа холбооны тухай зэрэг хуулиудтай уялдуулах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулна.

--ooOoo--